



## ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



## ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023

I



## ГАРЧИГ

### Нийгмийн үзүүлэлт:

I.	Нийгмийн даатгал.....	3
II.	Эрүүл мэнд.....	3
III.	Гэмт хэрэг.....	4
IV.	Гамшиг ослын мэдээ.....	5

### Эдийн засгийн үзүүлэлт:

I.	Мөнгө, банк.....	5
II.	Орон нутгийн төсөв.....	6
III.	Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ.....	7
IV.	Аж үйлдвэр.....	8

### Хавсралт хүснэгтүүд


## Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал 2023 оны 1 сарын байдлаар

### Нийгмийн үзүүлэлт



#### Нийгмийн даатгалын сангийн орлого 0.6 тэрбумаар буурчээ

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2023 оны эхний 1 сарын байдлаар 4.4 тэрбум төгрөг, зарлага 4.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 0.6 тэрбум төгрөгөөр буюу 12.3 хувиар буурч, зарлага 1.4 тэрбум төгрөг буюу 41.7 хувиар өссөн байна.



Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2023 оны 1 сарын байдлаар 4.3 тэрбум төгрөг болж, үүний 85.4 хувийг өндөр настны, 9.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.5 хувийг тэжээгчээ алдсаны, 3.1 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

1 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч хүн 8271 байна. Нийт тэтгэвэр авагчдын 85.4 хувь буюу 7060 хүн өндөр насны, 9.9 хувь буюу 817 хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэний, 2.8 хувь буюу 233 хүн тэжээгчээ алдсаны, 1.9 хувь буюу 161 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Оны эхний 1 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 195, YOMШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 18, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 41 хүн байна.


Тухайн сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 1908 байгаагийн 47.5 хувь буюу 1908 төр хариуцах иргэд, 40.6 хувь буюу 775 малчид, 1.6 хувь буюу 31 оюутан суралцагсад, 10.2 хувь нь буюу 195 аж ахуй нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.



#### Төрөлт өнгөрсөн оноос 12.5 хувиар өсжээ

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2023 оны 01 сарын байдлаар 64 эх төрсөн ба нийт 64 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 12.5 хувиар буюу 8 төрөлтөөр өссөн байна. Төрсөн эхчүүдийн 92.2 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт 1 сарын байдлаар 0-1 насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна. Нас

баралтын 50 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 10 тохиолдлоор буурсан. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 5 буюу 41.7 хувийг эзэлж байна. Тухайн жилийн эхний сарын байдлаар стационарит шинээр 1178 эмчлүүлэгч хэвтэж, 1117 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 816 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.3 байна.



2023 оны жилийн эхний 1 сарын байдлаар 16693 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 18.9 хувь, өвчний учир амбулаторийн үзлэг 69.3 хувь, идэвхтэй хяналт 6.8 хувь, гэрийн идэвхтэй үзлэг 2.8 хувь, гэрийн дуудлагын үзлэг 2.2 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 32.1 хувь нь эрэгтэй, 67.9 хувь нь эмэгтэй хүн байна

Халдварт өвчний 50 тохиолдол бүртгэгдээд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 10.5 болж өмнөх оны мөн үеэс 1871 тохиолдол буюу 388.8 пунктээр буурсан байна.




### Гэмт хэрэгт холбогдсон хүний тоо 31 болж өмнөх оны мөн үеэс 8 хүнээр өсжээ

Дундговь аймаг дахь Цагдаагийн газар нь 2023 оны 01 сарын байдлаар иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 127 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 18 (12.4%)-р буурсан байна.

2023 оны эхний 01 сард улсын хэмжээнд 3900 гэмт хэрэг бүртгэгдсэний 31(0.8%) нь Дундговь аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеэс 8(20.5%) хэргээр гэмт хэрэг өссөн байна.

2023 оны 01 сард бүртгэгдсэн гэмт хэрэг / Өмнөх 2 оны мөн үетэй харьцуулснаар/



Бүртгэгдсэн нийт 31 гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнийг санаатай алах гэмт хэрэг гараагүй байна. Бусад гэмт хэрэг 3(60%) хэргээр, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1(10%) хэргээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 1(1 дахин), хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг 2 (2 дахин) хэргээр, хулгайлах гэмт хэрэг 2(28.7%) хэргээр, мал хулгайлах гэмт хэрэг 1(50%) хэргээр буурсан байна. Дээрэмдэх гэмт хэрэг, хүчиндэх гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, залилах гэмт хэрэг ижил түвшинд байна.

Гэмт хэргийн улмаас хүн нас бараагүй, 32 иргэн хохирч, 13 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүний тоо 5(13.5%) хүнээр, гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо 2 (18.2%) хүнээр өссөн байна. Гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 2 (2 дахин) буурсан байна.

Гэмт хэрэгт нийт 17 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4(30.8%) хүнээр буурсан. Гэмт хэргийн илрүүлэлт Дундговь аймагт 28.6% байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 11.4 пунктээр өссөн, улсын дундаж /улсын дундаж илрүүлэлтийн хувь 16.8/ үзүүлэлтээс 11.8 пунктээр их үзүүлэлттэй байна.

Нийт гэмт хэргийн 8(25.8%) нь согтуугаар, 6(19.3%) нь эмэгтэй хүн оролцсон, 2(6.5%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг байна. Хүүхэд оролцсон, бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг гараагүй байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны 01 сарын байдлаар 1 360 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэс 59(4.5%) зөрчлөөр өссөн үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан 1 326 иргэнийг 52.8 сая төгрөгөөр торгосон байна. Үүнээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэргээр 21 хүнийг торгон, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасаж, 10 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Нийт 1 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 26 (96.3%) хүнээр буурсан байна.



### Малын гоц халдварт өвчин өнгөрсөн оны мөн үеэс 8 дахин өссөн байна


Аймгийн Онцгой байдлын газраас ирсэн мэдээгээр 2023 оны 01 дүгээр сарын байдлаар аюулт үзэгдэл, ослын 13 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс объектийн гал түймрийн дуудлага 4 удаа бүртгэгдсэн нь түрүү оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь иргэдийн санамсар, болгоомжгүй үйл ажиллагаанаас болж гал түймрийн тоо хохирол өсөх магадлалтай байгаа тул гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна. Мөн малын гоц халдварт шүлхий өвчин 8 суманд гарч, хорио цээрийн дэглэмийг сум орон нутгаас хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд бог малын мялзан өвчний нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Онцгой комиссоос ажлын хэсэг гарч бүх сумдад ажиллаж, уг өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх талаар сумдад үүрэг чиглэлийг өглөө.

## Эдийн засгийн үзүүлэлт




### Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өсжээ

Тус аймагт нийт 34 банкны салбар нэгжид 177 хүн ажиллаж байна. Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өсч, 144.8 тэрбум төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1.6 тэрбум төгрөг, чанаргүй зээл 1.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 2.1 дахин, чанаргүй зээл 34.8 хувиар тус тус өссөн байна.



Нийт зээлийн үлдэгдлийн 2.2 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар буурч, 82.8 тэрбум төгрөг болжээ.




## Улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих төлөвлөгөө 100.3 хувьтай байна

Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Татварын хэлтсийн мэдээгээр 2023 оны 1 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 32.1 хувьтай буюу 0.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 100.3 хувьтай буюу 84.2 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 0.8 тэрбум төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 34.5 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 5.4 тэрбум төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 77.8 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Дэлгэрцогт, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Сайнцагаан сумд 12.3-41.3 хувиар буюу 1.1-54.6 сая төгрөгөөр тасалдуулсан бол бусад сумд 3.6-124.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлого, зарлагын бүтэц



2023 оны 1 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зарлагын нийт дүн 2.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.4 хувиар буурсан байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оны мөн үеэс 27.5 хувиар буурч, 0.5 тэрбум төгрөг болсон нь нийт зардлын 22.2 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 37.6 хувиар буурч, 42.5 сая төгрөг болсон байна.

Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал томилолтын зардал 4.8 дахин өссөн бол бусад зардал 6.6-100.0 хувиар буурсан байна.




### Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс өнгөрсөн оноос 15.0 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2023 оны 1-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2022 оны 1-р сартай харьцуулахад 15.0 хувиар өсжээ.

Хэрэглээний үнийн индекс 15.0 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 19.1 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 15.2 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 19.7 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 7.8 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 26.1 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 14.2 хувиар, тээврийн бүлэг 8.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС  
/Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар/



2023 оны 01 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлшний үнийг орууллаа.

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногээр/

№	Барааны нэр, төрөл	I/02	I/09	I/16	I/23	I/30
1	Гурил, 1-р зэрэг, кг	2430	2430	2430	2450	2450
2	Хонины мах, кг	8000	8000	8000	8500	9000
3	Үхрийн мах, кг	0	0	0	0	0
4	Ямааны ястай мах, кг	7000	7000	7000	7500	8500
5	Элсэн чихэр, кг	3450	3450	3450	3450	3450
6	Цагаан будаа, кг	3700	3700	3700	3700	3700
7	Шингэн сүү, л	4000	4000	4000	4000	4000
8	Ноолуурын үнэ 1 кг	80000	80000	80000	80000	80000
9	Бензин А-80, 1литр	2510	2510	2510	2510	2510
10	Бензин А-92, 1литр	2530	2530	2530	2530	2530
11	Дизель түлш 1 литр	3980	3980	3980	3980	3980



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өнгөрсөн оны мөн үеэс  
3.3 дахин өсжээ

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2023 оны 1 сарын байдлаар 3.2 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3.3 дахин өссөн байна. Энэхүү өсөлтөд уул уурхай олборлох үйлдвэрлэл 13.9 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.



## ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД

## I. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2023.02.10

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
Сайнцагаан	55	59	7	6	0	0	0	0
Адаацаг	0	0	2	0	0	0	0	0
Баянжаргалан	0	1	3	1	0	0	0	0
Говь-Угтаал	0	0	2	0	0	0	0	0
Гурвансайхан	0	0	1	0	0	0	0	0
Дэлгэрхангай	0	2	0	0	0	0	0	0
Дэлгэрцогт	0	0	0	1	0	0	0	0
Дэрэн	0	0	0	1	0	0	0	0
Луус	0	0	1	1	0	0	0	0
Өлзийт	0	1	1	0	0	0	0	0
Өндөршил	1	1	2	0	0	0	0	0
Сайхан-Овоо	0	0	1	0	0	0	0	0
Хулд	0	0	0	0	0	0	0	0
Цагаандэлгэр	0	0	0	0	0	0	0	0
Эрдэнэдалай			2	0	0	0	0	0
Дүн	56	64	22	10	0	0	0	0

## II. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 01 сарын байдлаар

2023.02.10

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Бүртгэгдсэн бүх өвчлөл		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/			
	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	сүрьеэ		Салхин цэцэг	
	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
Сц	536	600	8883	13365	2272	4895	1029	39	0	0	0	23
Ад	0	19	444	279	2	203	54	3	0	0	0	2
Бж	19	23	78	104	0	19	20	0	0	0	0	0
Гу	42	16	84	185	0	170	84	0	0	0	0	0
Гс	7	14	149	128	14	4	83	3	0	0	0	1
Дх	21	60	40	244	5	8	114	1	1	0	0	0
Дц	24	36	128	127	18	36	28	1	1	0	0	0
Дн	18	30	122	197	27	32	48	2	0	0	0	1
Лс	23	22	368	179	20	16	53	1	0	0	0	0
Өт	25	23	194	201	13	21	79	0	0	0	0	0
Өш	23	36	271	172	28	67	35	0	0	0	0	0
Со	24	15	81	132	25	49	45	0	0	0	0	0
Хд	39	23	275	69	115	45	58	0	0	0	0	0
Цд	28	34	12	93	4	77	43	0	0	0	0	0
Эд	34	52	871	940	229	249	98	0	0	0	0	0
Мд	38	30	36	30	0	0	0	0	0	0	0	0
Эб	0	48	0	48	0	0	0	0	0	0	0	0
МУЭ төв	56	97	0	200	0	0	0	0	0	0	0	0
ДҮН	957	1178	12036	16693	2772	5891	1871	50	2	0	0	27

\* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

III. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВЭРИЙН САНХҮҮЖИЛТ  
мян.төг

2023.02.10

Сумд	Н.Д.Шимтгэлийн орлого			Тэтгэвэрийн санхүүжилт		
	төл	гүйц	хувь	олгох	олгосон	хувь
Сайнцагаан	938561.8	862543.5	91.9	1592193.9	1592193.9	100.0
Адаацаг	22456.0	20456.0	91.1	230770.9	230770.9	100.0
Баянжаргалан	31427.2	31427.2	100.0	95861.1	95861.1	100.0
Говь-Угтаал	39545.3	36245.3	91.7	154383.9	154383.9	100.0
Гурвансайхан	26527.8	24527.8	92.5	183981.8	183981.8	100.0
Дэлгэрхангай	27832.5	25832.5	92.8	203744.3	203744.3	100.0
Дэлгэрцогт	22055.4	20000.4	90.7	16692.6	16692.6	100.0
Дэрэн	18901.0	17501.0	92.6	191028.1	191028.1	100.0
Луус	30920.6	28620.6	92.6	177510.5	177510.5	100.0
Өлзийт	56900.7	52600.5	92.4	221205.4	221205.4	100.0
Өндөршил	24986.7	22846.7	91.4	132156.4	132156.4	100.0
Сайхан-Овоо	12412.9	11412.9	91.9	166321.8	166321.8	100.0
Хулд	30694.0	27694.0	90.2	215450.0	215450.0	100.0
Цагаандэлгэр	18741.2	18741.2	100.0	89744.2	89744.2	100.0
Эрдэнэдалай	11896.7	11896.7	100.0	530720.7	530720.7	100.0
Дүн	1313859.7	1212346.2	92.3	4201765.6	4201765.6	100.0

IV. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, ЗАРЛАГА/сая.төг/

2023.02.10

	2022 оны I сар	2023 оны I сар			<u>2023 I</u>
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	<u>2022 I</u> хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	5032.2	2030.9	4413.8	217.3	87.7
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	4664.3	1800.7	4114.8	228.5	88.2
Тэтгэмжийн даатгалын сангийн	74.8	108.7	53.4	49.1	71.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн	200.1	0.0	122.3	0.0	94.8
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	52.3	104.7	49.3	47.1	94.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	40.7	16.8	6.6	39.3	16.2
Нийгмийн даатгалын сангийн зарлага	3486.3	5074.2	4940.5	97.4	141.7
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	3157.8	4680.6	4542.8	97.1	143.9
Тэтгэмжийн даатгалын сангийн	130.2	294.9	166.3	56.4	127.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн	122.3	0.0	68.9	0.0	56.3
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	20.5	18.0	111.5	619.4	543.9
Ажилгүйдлийн даатгалын сангийн	55.5	80.7	51.0	63.2	91.9

## V. ГАМШГИЙН МЭДЭЭ

2023.02.10

Үйл ажиллагаа	2022 оны 01 сар	2023 оны 01 сар	2022/2023 хувь
Нийт ирсэн дуудлага	0	13	0.0
Объектын гал түймрийн	2	4	200.0
Хүчтэй салхи шуурга	0	0	0.0
Усны осол	0	0	0.0
Төөрсөн сураггүй болсон	0	1	0.0
Зам тээврийн осол	0	0	0.0
Уурхайн осол	0	0	0.0
Аянга	0	0	0.0
Малын гоц халдварт	1	8	800.0
Сум галт хэрэгсэл	0	0	0.0
<b>Дуудлагын үр дүн</b>			
Аварсан хүн	0	0	0.0
Аварсан хөрөнгө /сая.төг/	18	16	88.9
Хохирол /сая.төг/	14.6	39.4	269.9
<b>Иргэд ААН-д хандсан үйл ажиллагаа</b>			
ААН-ийн хүсэлт	8	21	262.5
Иргэдийн өргөдөл	17	10	58.8
<b>Хяналт шалгалт</b>			
Хамрагдсан объект	18	28	155.6
Илэрсэн зөрчил	75	117	156.0
Газар дээр нь арилгасан	35	17	48.6
Албан шаардлага	5	0	0.0
Мэдэгдэл	13	22	169.2
Торгууль /сая.төг/	0	0	0.0

## VI. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-1

2/10/2023

Үзүүлэлт		2022 I	2023 I	23/22 хувь
	Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо	30684	30773	100.3
	Бүх хэрэг	39	31	79.5
	Хүнийг санаатай алах гэмт хэрэг	0	0	-
	Хүчиндэх гэмт хэрэг	1	1	100.0
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	2	0	-
	Дээрэмдэх гэмт хэрэг	1	1	100.0
Хэргийн өнгө	Хүрээлэн байгаа орчны эсрэг	1	0	0.0
	Танхайн хэрэг	0	0	-
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	10	11	110.0
	Бусдын эд хөрөнгийн хулгай	7	5	71.4
	Малын хулгай	2	1	50.0
	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг	3	3	100.0
	Залилангийн хэрэг	7	7	100.0
	Эдийн засгийн гэмт хэрэг	0	0	-
	Бусад	5	2	40.0
	Хэргийн нөхцөл	Эмэгтэй хүн оролцсон	2	6
Согтуугаар		6	8	133.3
Бүлэглэж		0	0	-
Хүүхэд оролцсон		0	0	-
Хэргийн ангилал	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	3	2	66.7
	Хөнгөн	28	29	103.6
	Хүнд	10	3	30.0
	Гэмт хэрэгт холбогдогсод	13	17	130.8
	Учирсан бүх хохирол /сая.төг/	81.5	142.3	174.6
	Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/	12.9	30.5	236.4
	Илрүүлэлтийн хувь	17.2	28.6	166.3
	18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/	13	10	79.3

## VII. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-2

2/10/2023

№	Үзүүлэлтүүд	2022 I	2023 I	2022/2021 хувь
	Гэмт хэргийн улмаас	13	13	100.0
1	Нас барсан	2	0	0.0
	Гэмтсэн	11	13	118.2
	Зам тээврийн осолын улмаас	3	3	100.0
2	Нас барсан	0	2	-
	Гэмтсэн	3	1	33.3
	Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо	37	32	86.5
3	Эмэгтэй	13	12	92.3
	7 хүртэлх насны	0	1	-
	8-13 насны	0	1	-
	14-17 насны	3	0	0.0
	Бүх хүлээн авсан өргөдөл, гомдол мэдээлэл	145	127	87.6
	Бүх шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй ӨГМ	49	64	130.6
	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	12	14	116.7
4	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	16	25	156.3
	Харьяаллын дагуу шилжүүлсэн	1	1	100.0
	Үлдэгдэл	20	26	130.0
	Бүх шийдсэнээс 5 хоногт шийдвэрлэсэн	5	7	140.0
	6-ба түүнээс дээш	24	33	137.5
	Бүх шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн шинжтэй ӨГМ-лэл	96	63	65.6
5	5 хоногт	73	56	76.7
	6 ба түүнээс дээш	14	4	28.6
	Үлдэгдэл	9	3	33.3
6	Нийт зөрчил	1301	1360	104.5
	ЗЦТасгаас илрүүлсэн	1037	838	80.8
7	Торгуулийн арга хэмжээ авсан	264	522	197.7
	НХЖХТасгаас илрүүлсэн			
8	Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасч, торгосон	35	21	60.0
9	Баривчлагдсан хүн	2	10	500.0
10	Журамласан тээврийн хэрэгсэл	49	30	61.2
11	Эрүүлжүүлэгдсэн хүн	27	1	3.7
12	Зөрчлийн хуулиар арга хэмжээ авагдсан	Хүний тоо Мөнгөн дүн /сая.төг/	1257 1326	105.5 345.1

## VIII. ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ

2023.02.10

(Сая.төгрөг,тоогоор)

Үзүүлэлт			Үлдэгдэл		2023/2022 2 хувь
			2022 I	2023 I	
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл		142023.7	144849.8	102.0
	Үүнээс:	Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	751.2	1,611.3	214.5
		Чанаргүй зээлийн үлдэгдэл	1116.7	1505.3	134.8
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл		20858.7	24019.4	115.2
	Үүнээс:	Иргэдийн харилцахын үлдэгдэл	13491.5	17090.5	126.7
	Нийт хадгаламжийн үлдэгдэл		93450.6	82790.4	88.6
	Үүнээс:	Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	93351.5	82771.4	88.7
		Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	16965.0	11830.8	69.7
		Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	76485.6	70959.7	92.8
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо		34	34	100.0
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо		168	177	105.4
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)		24854	25399	102.2
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		85743	87457	102.0
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		34347	32197	113.7
	Нийт АТМ-ны тоо		21	18	85.7
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо		46103	45419	98.5

## IX. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

Сумд	2023 I			2023 I сар		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Сайнцагаан	274117.0	219526.2	80.1	274117.0	219526.2	80.1
Адаацаг	11018.4	12258.4	111.3	11018.4	12258.4	111.3
Баянжаргалан	8773.9	19701.1	224.5	8773.9	19701.1	224.5
Говь-Угтаал	11323.5	9636.5	85.1	11323.5	9636.5	85.1
Гурвансайхан	14923.0	12934.4	86.7	14923.0	12934.4	86.7
Дэлгэрхангай	27728.1	34695.9	125.1	27728.1	34695.9	125.1
Дэлгэрцогт	9603.4	8426.0	87.7	9603.4	8426.0	87.7
Дэрэн	9093.3	11769.0	129.4	9093.3	11769.0	129.4
Луус	9312.1	9649.2	103.6	9312.1	9649.2	103.6
Өлзийт	10560.0	7159.8	67.8	10560.0	7159.8	67.8
Өндөршил	9601.7	12103.2	126.1	9601.7	12103.2	126.1
Сайхан-Овоо	12560.3	10111.1	80.5	12560.3	10111.1	80.5
Хулд	13724.0	8043.3	58.6	13724.0	8043.3	58.6
Цагаандэлгэр	7141.9	9044.4	126.6	7141.9	9044.4	126.6
Эрдэнэдалай	24450.0	26667.5	109.1	24450.0	26667.5	109.1
Дундговь	62271.7	76667.1	123.1	62271.7	76667.1	123.1
Дүн	516202.3	488393.1	94.6	516202.3	488393.1	94.6

## Х.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, сая төгрөгөөр

2023.01.10

Үзүүлэлт	мөр	2022 I	2023 I			23/22
			төл	гүйц	хувь	хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО /тусламжийн дүн/	1	6290.6	6984.6	5433.8	77.8	86.4
А.УРСГАЛ ОРЛОГО	2	492.5	2252.8	719.8	32.0	146.1
I.ТАТВАРЫН ОРЛОГО	3	320.2	368.9	308.0	83.5	96.2
1.1 Хүн амын орлогын албан татвар	4	266.2	337.7	215.8	63.9	81.1
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	5	254.2	329.5	183.2	55.6	72.1
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	6	0.0	-3.3	0.0	0.0	-
1.2 үйл ажиллагааны орлого	7	11.6	8.5	23.8	279.5	205.5
1.3 Хөрөнгө борлуулсаны	8	0.5	3.0	8.8	293.6	1797.3
1.5 Бусад татвар	9	0.0	0.0	0.0	-	-
2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/	10	1.6	5.2	13.3	254.2	848.3
3. Авто тээврийн хэрэгслийн	11	9.8	0.0	41.4	-	421.5
4. Бусад татвар	12	42.6	25.9	37.4	144.2	87.8
4.1 Улсын тэмдэгтийн	13	10.8	11.6	11.4	98.9	105.8
4.2 Ашигт малтмал нөөцийн	14	0.2	0.0	0.0	-	0.0
4.3 Газрын төлбөр	15	4.7	6.4	23.0	361.6	484.6
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	16	0.7	8.0	1.0	12.8	152.1
4.6 Усны төлбөр	17	1.6	0.0	0.0	-	0.2
4.7.Бусад	18	8.6	0.0	2.0	-	23.3
4.7.Малд ногдуулах	19	15.9				
II.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20	172.3	1883.9	411.9	21.9	101.6
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	21	105.4	1792.0	316.9	17.7	300.6
2.2 Бусад нэр заагдаагүй	22	66.9	91.9	95.0	103.3	142.0
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	23	0.9	3.0	3.5	118.1	389.4
V.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	24	5797.1	4728.8	4710.5	99.6	81.3
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	25	1217.5	1177.7	1177.7	100.0	96.7
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	26	0.0	0.0	0.0	-	-
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих	27	0.0	0.0	0.0	-	-
Хандив тусламж	28	0.0	0.0	0.0	0.0	0.0
Төсвөөс санхүүжих	29	3537.7	2732.3	2713.9	99.3	76.7
Аймаг нийслэлээс авсан татаас	30	1041.9	818.8	818.8	100.0	78.6
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	31	493.5	2255.8	723.4	32.1	146.6
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	32	77.1	83.9	84.2	100.3	109.2
Аймгийн нийт орлого	33	570.5	2339.7	807.5	34.5	141.5

ХI.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр  
2023.02.10

Зарлагын төрөл	2022 I	2023 I			2023 I/ 2022 I
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
НИЙТ ЗАРЛАГА	3074.3	8529.7	2139.0	25.1	69.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656.5	634.2	475.8	75.0	72.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68.0	78.9	42.5	75.0	62.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	628.2	814.1	553.6	53.8	88.1
Хангамж бараа материалын зардал	8.7	50.1	6.4	12.8	73.5
Норматив зардал	0.0	0.0	0.0	-	-
Эд хогшил урсгал засварын зардал	0.0	14.6	0.2	1.7	-
Томилолтын зардал	1.0	14.5	4.6	31.9	478.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	55.2	24.7	9.5	38.4	17.1
Бараа үйлчилгээний бусад зардал	186.3	2048.1	173.9	8.5	93.4
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.0	84.6	8.0	9.5	-
Засгийн газрын дотоод шилжүүлэг	1105.3	818.8	818.8	100.0	74.1
Бусад урсгал шилжүүлэг	235.5	11.2	0.0	0.0	0.0
Хөрөнгийн зардал	129.7	3936.0	45.7	1.2	35.2
Эргэж төлөгдөх зээл	0.0	0.0	0.0	0.0	0.0



XII. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 1-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ/аймгаар/  
2/10/2023

	Нэр төрөл	Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь	Дорноговь
1	Гурил, дээд зэрэг /Алтантариа/	2875.0	2467.0	2737.0	2500.0
2	Гурил, 1-р зэрэг /Алтантариа/	2450.0	2050.0	2253.0	2000.0
3	Гурил, 2-р зэрэг /Алтантариа/	2217.0	950.0	1545.0	1600.0
4	Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай	1967.0	1816.0	1763.0	1817.0
5	Талх, орон нутгийн үйлдвэрийн	2183.0	2250.0	2433.0	2367.0
6	Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/	5800.0	4666.0	4650.0	4233.0
7	Жигнэмэг /наша марка/150-180г, цайны/	1975.0	1750.0	1860.0	1900.0
8	Цагаан будаа, задгай, кг	3697.0	3500.0	3725.0	3433.0
9	Шар будаа, задгай, кг	3230.0	3225.0	3250.0	2933.0
10	Хонины мах, кг	8000.0	8000.0	9000.0	8000.0
11	Адууны мах, кг	8250.0	-	-	8833.0
12	Ямааны мах, кг	7000.0	6500.0	7000.0	6667.0
13	Дотор мах, цувдай, цусгүй	3000.0	-	5000.0	3500.0
14	Хиам чанасан, 1кг	-	-	-	12500.0
15	Сүү, задгай, л	4000.0	4000.0	4500.0	3500.0
16	Сүү савласан, 1л. Шимт сүү	-	4216.0	-	4133.0
17	Хорхой ааруул, задгай, чихэртэй	30000.0	21000.0	25000.0	22500.0
18	Өндөг,ш,дотоод	550.0	550.0	577.0	550.0
19	Ургамлын тос, 1литр, Олайна	10767.0	11400.0	10580.0	10067.0
20	Өөхөн тос, кг	-	-	577.0	3000.0
21	Шар тос, кг	32000.0	33500.0	35000.0	30500.0
22	Цөцгийн тос, задгай, кг	11667.0	10100.0	12300.0	10950.0
23	Төмс дотоод, кг	1497.0	1800.0	2333.0	1800.0
24	Лууван хятад, кг	1897.0	1633.0	2600.0	2933.0
25	Байцаа хятад, кг	1947.0	1966.0	2300.0	2233.0
26	Сонгино хятад, кг	2963.0	3900.0	3367.0	3067.0
27	Элсэн чихэр, кг, орос	3450.0	3350.0	3450.0	3900.0
28	Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/	12400.0	8800.0	8550.0	12700.0
29	Шоколад, "Alpen gold"	3650.0	3850.0	3947.0	3500.0
30	Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	2500.0	2433.0	2770.0	2567.0
31	Майноз, /Золотой 500г/	6730.0	5950.0	6777.0	6750.0
32	Кетчуп, 900г, Чили Полиш	2733.0	4300.0	3130.0	3150.0
33	Ногоон цай, Stimo, савласан 90г	3200.0	3400.0	2330.0	2883.0
34	Байхуу цай, Lipton, 20 ширхэгтэй	4800.0	4600.0	3693.0	3750.0
35	Цагаан архи, 0.75 ARKHI EXPORT	24933.0	23750.0	24000.0	23650.0
36	Пиво, "Cass", 0.5л	4113.0	4050.0	3927.0	3000.0
37	Янжуур тамхи, /Esse/, саарал	3967.0	3700.0	3760.0	3500.0
38	Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи	2950.0	2450.0	2233.0	1997.0
39	Бензин, А-80, 1 литр	2510.0	2460.0	2395.0	2490.0
40	Бензин, А-92, 1 литр	2530.0	2480.0	2547.0	2520.0
41	Дизель түлш, 1 литр	3980.0	3940.0	3990.0	3957.0

## XIII. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

2110/2023

	2023 2022 I	2023 2022 XII
<b>ЕРӨНХИЙ ИНДЕКС</b>	<b>115.0</b>	<b>101.0</b>
<b>01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА</b>	<b>119.1</b>	<b>102.6</b>
01.1 ХҮНСНИЙ БАРАА	117.8	102.8
01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА	130.2	102.1
01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН	94.5	104.6
01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН	121.0	100.0
01.1.4 СУУ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ	121.5	108.0
01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС	152.7	100.0
01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ	97.2	99.6
01.1.7 ХҮНСНИЙ НОГОО	127.6	100.4
01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР	121.0	101.6
01.1.9 БЭЛЭН ХООЛ, ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН	115.7	101.6
01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	130.9	101.0
<b>02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС</b>	<b>115.2</b>	<b>100.7</b>
02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА	125.7	101.5
02.2 ТАМХИ	111.0	100.3
<b>03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ</b>	<b>119.7</b>	<b>100.6</b>
03.1 ХУВЦАС, БӨС БАРАА	118.5	101.0
03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА	120.1	105.7
03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС	118.9	100.6
03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ	110.9	101.1
03.2 ГУТАЛ	121.6	100.0
<b>04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ</b>	<b>107.8</b>	<b>100.0</b>
04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС	107.1	100.0
04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	116.7	100.0
04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	107.7	100.0
04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	100.7	100.1
<b>05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА</b>	<b>126.1</b>	<b>100.5</b>
05.1 ГЭР АХУЙН ТАВИЛГА, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	131.0	100.0
05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	118.4	102.0
05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	125.8	100.0
05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	111.3	100.0
05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ	127.9	103.3
05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСАД ҮЙЛЧИ	124.6	100.9
<b>06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>114.2</b>	<b>100.9</b>
06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ	116.8	101.3
06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	113.6	100.0
06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
<b>07. ТЭЭВЭР</b>	<b>108.8</b>	<b>100.0</b>
07.1 ТЭЭВРИЙН ХЭРГЭСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	100.0	100.0
07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ	114.4	100.0
07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
<b>08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>101.3</b>	<b>100.3</b>
08.2 МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ	103.9	100.9
08.3 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
<b>09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>116.4</b>	<b>105.0</b>
09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	112.1	106.4
09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	120.3	106.1
<b>10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>159.6</b>	<b>100.0</b>
11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	160.5	100.0
11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
<b>12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>118.3</b>	<b>100.6</b>
12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	120.1	100.7
12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	108.5	100.0
12.5 ДААТГАЛ	118.7	118.7
12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0

## XIV. ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН МЭДЭЭ

2023.02.10

		Хэмжих нэгж	2022 оны 12 сар	2023 он
				1 р сар
1. Малын үнэ /мян.төг/				
Тэмээ				
Нас гүйцсэн	эр	тол	1,683.3	1,726.9
	эм	тол	1,412.5	1,415.4
Өсвөр насны	эр	тол	1,031.8	1,009.1
	эм	тол	990.9	990.0
Адуу				
Нас гүйцсэн	эр	тол	1,153.60	1,250.0
	эм	тол	1,082.30	1,146.2
Өсвөр насны	эр	тол	819.2	827.3
	эм	тол	788.5	772.7
Үхэр				
Нас гүйцсэн	эр	тол	1569.2	1,576.9
	эм	тол	1319.2	1,408.3
Өсвөр насны	эр	тол	807.7	783.3
	эм	тол	773.1	755.6
Бог мал				
Нас гүйцсэн хонь	эр	тол	212.3	209.6
	эм	тол	146.4	158.3
Нас гүйцсэн ямаа	эр	тол	151.0	157.7
	эм	тол	111.4	108.8
2. Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ /мян.төг/				
Тэмээний ноос		кг		
Ямааны ноолуур		кг		
Тэмээний шир		ш	15.0	23.0
Адууны шир		ш	5.0	12.0
-2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир		ш	8.0	10.0
-2 м-ээс дээш хэмжээтэй үхрийн шир		ш		-
Хонины ноостой, өлөн гэдэстэй арьс		ш	4.0	2.0
Ямааны ноолууртай, өлөн арьс		ш	35.0	42.0

## XV. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ (оны үнээр )

2023.02.10

сая.төг

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР	2022 I	2023 I	2023/2022 хувь
<b>НИЙТ ДҮН</b>	<b>982.9</b>	<b>3,235.8</b>	<b>329.2%</b>
<b>УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ</b>	<b>172.0</b>	<b>2,383.0</b>	<b>1385.5%</b>
Чулуун нүүрс олборлолт	73.9	2,190.7	2964.4%
Хүрэн нүүрс олборлолт	98.1	113.2	115.4%
Дээрх ангилалд ороогүй бусад ашигт малтмалын олборлолт	0.0	79.1	-
<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ</b>	<b>231.2</b>	<b>120.2</b>	<b>52.0%</b>
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	181.7	115.4	63.5%
Малын тэжээлийн үйлдвэрлэл	0.0	0.9	-
Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	3.8	3.5	92.1%
Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	44.9	0.0	0.0%
Хэвлэх болон хэвлэлийн туслах үйл ажиллагаа	0.8	0.4	50.0%
Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл	0.0	0.0	-
<b>ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ</b>	<b>481.8</b>	<b>580.9</b>	<b>120.6%</b>
Уур, агааржуулагчийн хангамжийн үйл ажиллагаа	481.8	580.9	120.6%
<b>УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>97.9</b>	<b>151.7</b>	<b>155.0%</b>
Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	52.1	102.0	195.8%
Хог хаягдлыг цуглуулах	45.8	49.7	108.5%

## XVI. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

2023.02.10

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2022 I	2023 I	2023/2022 хувь
Нүүрс	мян.тн	233.8	216.7	92.7
Жонш	мян.тн	19.5	3.8	19.5
Гөлтгөнө	мян.тн	0.0	8.5	-
Дулааны эрчим хүч	мян.гкал	115.6	127.8	110.6
Хүснэгт, маягт	х.д.х	398.0	347.4	87.3
Талх	тн	144.7	121.4	83.9
Нарийн боов	тн	162.2	141.1	87.0
Чихэр	тн	2.5	3.9	156.0
Архи	мян.л	12.4	15.6	125.8
Хиамны зүйл	тн	0.3	0.0	0.0
Сүү, тараг	мян.л	0.0	0.0	-
Хоормог	мян.л	0.0	0.2	-
Ааруул	тн	0.3	0.7	233.3
Модон эдлэл	мян.төг	131049.0	153391.7	117.0
Түгээсэн цэвэр ус	мян.т <sup>3</sup>	281.1	219.6	78.1
Сувагжуулалт	мян.м <sup>3</sup>	176.4	147.2	83.4
Оёдол эсгүүр	мян.төг	109650.0	39263.3	35.8

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

[www.1212.mn](http://www.1212.mn)



Дундговь аймгийн  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



[www.dundgovi.nso.mn](http://www.dundgovi.nso.mn)

Материалыг бэлтгэсэн:

Т.Бямбасүрэн  
С.Доржханд  
Г.Ариунжаргал  
Н.Давааням

Утас 70593714, 70593715  
70593777

2023 оны 02 сарын 12

ХЯНАСАН: СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Б.ЭНХТУЯА